



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндуг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МСҮТ	Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.САРАНГЭРЭЛ ТАНАА

2023.02.25 № 188
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,635,334.4 мянган төгрөг буюу 58.0 хувиар буурсан нь Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,133,262.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого /ковид-19 холбоотой нэмэлт санхүүжилтүүд/ 920,179.7 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

2022 оны захирамж, шийдвэр гарсан Э-121300094 гэрчилгээний дугаартай 639,075.0 мянган төгрөгийн газар, Э-1213000349 гэрчилгээний дугаартай 30,060.0 мянган төгрөгийн газар Нийт 669,135.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг биет бус хөрөнгөд бүртгэн авсан байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотойгоор Сүхбаатар аймгийн баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны 15/12 тоот тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын 103,075.7 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөөр, 47,500.0 мянган төгрөгийн ариутгалын автомашиныг тээврийн хэрэгслээр, Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, Тамгын даргын Б/137 тоот тушаалын дагуу төсвийн хөрөнгөөр худалдан авсан 22,478.3 мянган төгрөгийн хөрөнгийг

тоног төхөөрөмжөөр, 10,896.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөөр, 1,995.0 мянган төгрөгийн программ хангамжийг тус тус бүртгэлд нэмж тусгасан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 1-ны Д/432 тоот албан бичгээр 36,883.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 24,312.4 мянган төгрөгийн Тавилга эд хогшил, 13,721.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 915.0 төгрөгийн программ хангамж, нийт 75,831.7 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий хөрөнгийг актлах зөвшөөрөл ирсний үндсэн дээр хөрөнгийг баланс бүртгэлээс хасалт хийсэн.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 33 зорилтын хүрээнд 117 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 92.4 хувьтай биелсэн гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>295 561 923,41</u>	<u>330 873 554,21</u>
33	АВЛАГА	17 670 908,00	6 740 310,00
335	Бусад авлага	17 670 908,00	6 740 310,00
3351	Байгууллагаас авах авлага	16 400 908,00	5 470 310,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1 270 000,00	1 270 000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>277 891 015,41</u>	<u>324 133 244,21</u>
354	Хангамжийн материал	<u>69 216 015,41</u>	<u>91 593 244,21</u>
35410	Бичиг хэргийн материал	6 073 910,00	1 488 850,00
35420	Аж ахуйн материал	1 370 523,00	1 108 123,00
35470	Бусад хангамжийн материал	61 771 582,41	88 996 271,21
35500	Биологийн хөрөнгө	207 415 000,00	202 540 000,00
35600	Мал амьтад	1 260 000,00	30 000 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3 357 202 796,51</u>	<u>3 945 610 912,69</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>3 357 202 796,51</u>	<u>3 945 610 912,69</u>
392	Биет хөрөнгө	<u>3 337 966 796,51</u>	<u>3 255 244 912,69</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	431 778 460,61	431 778 460,61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37 753 346,28	-51 710 576,76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217 854 800,00	265 354 800,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-133 764 420,28	-153 677 800,36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184 663 109,20	170 258 346,80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112 731 539,61	-102 948 595,31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	151 051 750,40	126 739 360,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-84 215 166,93	-75 669 609,25
39209	Зам, гүүрийн байгууламж	161 789 472,00	161 789 472,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2 696 491,20	-8 089 473,60
39214	Бусад үндсэн хөрөнгө	3 084 178 852,00	3 184 429 342,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-522 188 683,40	-693 008 813,44
393	Биет бус хөрөнгө	<u>19 236 000,00</u>	<u>690 366 000,00</u>
39301	Програм хангамж	1 662 500,00	2 742 500,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 662 500,00	-747 500,00
39303	Бусад биет бус хөрөнгө	19 236 000,00	688 371 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3 652 764 719,92</u>	<u>4 276 484 466,90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>42 149 273,00</u>	<u>2 752 340,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>42 149 273,00</u>	<u>2 752 340,00</u>
413	Өглөг	<u>42 149 273,00</u>	<u>2 752 340,00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36 440,00	36 440,00
4136	Бусад өглөг	<u>42 112 833,00</u>	<u>2 715 900,00</u>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9 435 900,00	2 715 900,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3 610 615 446,92</u>	<u>4 273 732 126,90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>3 610 615 446,92</u>	<u>4 273 732 126,90</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 242 342 616,37	1 242 342 616,37
51101	Өмч: - төрийн	1 242 342 616,37	1 242 342 616,37
512	Хуримтлагдсан үр дүн	<u>2 329 680 479,15</u>	<u>2 992 797 159,13</u>

51210	Өмнөх үеийн үр дүн	2 329 680 479,15	2 329 680 479,15
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	663 116 679,98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38 592 351,40	38 592 351,40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 652 764 719,92	4 276 484 466,90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4 454 141 374,00	2 818 806 990,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1 987 972 693,00	854 710 730,00
120	Нийтлэг татварын бус орлого	1 987 972 693,00	854 710 730,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1 987 972 693,00	854 710 730,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1 987 972 693,00	854 710 730,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 466 168 681,00	1 964 096 260,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 113 262 081,00	193 082 360,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10 797 240,00	193 082 360,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1 352 906 600,00	1 771 013 900,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	1 352 906 600,00	1 771 013 900,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 637 912 578,16	2 154 639 391,46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 637 912 578,16	2 154 639 391,46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 583 134 980,64	2 019 962 104,26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590 434 824,24	652 085 517,07
210101	Үндсэн цалин	379 098 139,38	431 389 527,96
210102	Нэмэгдэл	156 507 250,81	120 424 166,58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00,00	18 361 055,24
210104	Урамшуулал	00,00	45 024 324,30
210105	Гэрээт ажлын хөлс	54 829 434,05	36 886 442,99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78 297 435,65	82 740 005,91
210201	Тэтгэврийн даатгал	52 912 435,65	56 565 749,57
210202	Тэтгэмжийн даатгал	5 419 151,13	6 633 456,78
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 959 948,87	5 229 465,72
210204	Ажилгүйдлийн даатгал	1 264 300,00	1 300 875,75
210205	Эрүүл мэндийн даатгал	12 741 600,00	13 010 458,09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135 957 206,00	132 717 451,21
210301	Гэрэл, цахилгаан	9 367 053,00	7 427 324,77
210302	Түлш, халаалт	55 590 153,00	53 069 744,24
210303	Цэвэр, бохир ус	2 200 000,00	2 620 382,20
210304	Байрны түрээс	68 800 000,00	69 600 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	80 179 843,00	80 642 346,61
210401	Бичиг хэрэг	18 002 990,00	22 710 400,00
210402	Тээвэр, шатахуун	34 339 000,00	43 392 050,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7 315 132,00	8 355 841,61
210404	Ном, хэвлэл	00,00	60 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20 522 721,00	6 124 055,00
2105	Нормативт зардал	6 803 476,00	645 970,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6 803 476,00	645 970,00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36 329 680,21	79 398 791,20
210601	Багаж, техник, хэрэгсэл	64 500,00	5 180 300,00
210604	Урсгал засвар	36 265 180,21	74 218 491,20
2107	Томилолт, зочны зардал	8 903 000,00	11 006 000,00
210702	Дотоод албан томилолт	8 903 000,00	11 006 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 114 804 153,00	146 613 608,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 113 107 228,00	142 937 955,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 430 000,00	1 000 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	189 925,00	391 757,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77 000,00	55 000,00
210807	Газрын төлбөр	00,00	2 228 896,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	531 425 362,54	834 112 414,26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	333 318 005,59	548 364 752,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30 137 840,00	20 126 667,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	167 969 516,95	265 620 995,26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54 777 597,52	134 677 287,20
2132	Бусад урсгал шилжүүлэг	49 084 331,00	115 129 497,58
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7 153 400,00	15 938 600,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20 059 269,00	15 641 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21 871 662,00	83 549 897,58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5 693 266,52	19 547 789,62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5 693 266,52	19 547 789,62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1 816 228 795,84	664 167 598,54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	284 809 500,00	1 050 918,56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00,00	1 050 918,56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-284 809 500,00	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1 531 419 295,84	663 116 679,98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2 466 168 681,00	1 964 096 260,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 466 168 681,00	1 964 096 260,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1 113 262 081,00	193 082 360,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10 797 240,00	193 082 360,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1 352 906 600,00	1 771 013 900,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1 352 906 600,00	1 771 013 900,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2 437 193 381,00	1 939 622 960,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 437 193 381,00	1 939 622 960,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 371 434 261,48	1 808 182 572,80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594 098 428,83	648 148 717,07
210101	Үндсэн цалин	382 761 743,97	442 504 302,64
210102	Нэмэгдэл	156 507 250,81	102 415 834,66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00,00	20 356 582,00
210104	Урамшуулал	00,00	45 024 324,30

210105	Гэрээт ажлын хөлс	54 829 434,05	37 847 673,47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78 297 435,65	82 740 005,91
210201	Тэтгэврийн даатгал	52 912 435,65	56 565 749,57
210202	Тэтгэмжийн даатгал	5 419 151,13	6 633 456,78
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 959 948,87	5 229 465,72
210204	Ажилгүйдлийн даатгал	1 264 300,00	1 300 875,75
210205	Эрүүл мэндийн даатгал	12 741 600,00	13 010 458,09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135 957 206,00	132 717 451,21
210301	Гэрэл, цахилгаан	9 367 053,00	8 007 324,77
210302	Түлш, халаалт	55 590 153,00	53 069 744,24
210303	Цэвэр, бохир ус	2 200 000,00	2 620 382,20
210304	Байрны түрээс	68 800 000,00	69 020 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	60 146 568,00	77 889 726,61
210401	Бичиг хэрэг	9 999 320,00	15 613 320,00
210402	Тээвэр, шатахуун	33 000 000,00	46 478 910,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7 278 392,00	8 386 861,61
210404	Ном, хэвлэл	500 000,00	760 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9 368 856,00	6 650 635,00
2105	Нормативт зардал	7 300 000,00	607 670,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7 300 000,00	607 670,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32 884 600,00	85 055 080,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00,00	7 405 300,00
210604	Урсгал засвар	32 779 600,00	77 649 780,00
2107	Томилолт, зочны зардал	9 563 000,00	11 006 000,00
210702	Дотоод албан томилолт	9 563 000,00	11 006 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 119 821 006,00	210 635 363,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 118 114 081,00	206 959 710,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 430 000,00	1 000 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	189 925,00	391 757,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77 000,00	55 000,00
210807	Газрын төлбөр	00,00	2 228 896,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333 366 017,00	559 382 559,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	307 566 168,00	537 452 552,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25 799 849,00	21 930 007,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65 759 119,52	131 440 387,20
2132	Бусад урсгал шилжүүлэг	60 065 853,00	111 892 597,58
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7 153 400,00	16 938 600,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20 524 269,00	15 641 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32 388 184,00	79 312 997,58
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5 693 266,52	19 547 789,62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5 693 266,52	19 547 789,62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28 975 300,00	24 473 300,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28 975 300,00	24 473 300,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28 975 300,00	24 473 300,00
2200	Дотоод эх үүсвэрээр	28 975 300,00	24 473 300,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28 975 300,00	24 473 300,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28 975 300,00	-24 473 300,00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 242 342 616,37	38 592 351,40	798,261,183.31	2,079,196,151.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	1,531,419,295.84	1,531,419,295.84
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 242 342 616,37	38 592 351,40	2,329,680,479.15	3,610,615,446.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 242 342 616,37	38 592 351,40	2,329,680,479.15	3,610,615,446.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	663 116 679,98	663 116 679,98
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 242 342 616,37	38 592 351,40	2 992 797 159,13	4 273 732 126,9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 829 087 100,00	1 771 013 900,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 829 087 100,00	1 771 013 900,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 719 142 900,00	1 643 044 442,80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684 319 700,00	648 148 717,07
210101	Үндсэн цалин	454 653 900,00	442 504 302,64
210102	Нэмэгдэл	106 940 400,00	102 415 834,66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29 624 000,00	20 356 582,00
210104	Урамшуулал	50 329 600,00	45 024 324,30
210105	Гэрээт ажлын хөлс	42 771 800,00	37 847 673,47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85 966 800,00	82 740 005,91
210201	Тэтгэврийн даатгал	58 458 800,00	56 565 749,57
210202	Тэтгэмжийн даатгал	6 877 000,00	6 633 456,78
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 501 700,00	5 229 465,72
210204	Ажилгүйдлийн даатгал	1 375 300,00	1 300 875,75
210205	Эрүүл мэндийн даатгал	13 754 000,00	13 010 458,09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136 800 000,00	132 717 451,21
210301	Гэрэл, цахилгаан	10 000 000,00	8 007 324,77
210302	Түлш, халаалт	54 700 000,00	53 069 744,24
210303	Цэвэр, бохир ус	2 500 000,00	2 620 382,20
210304	Байрны түрээс	69 600 000,00	69 020 000,00

2104	Хангамж, бараа материалын зардал	84 110 000,00	77 889 726,61
210401	Бичиг хэрэг	14 500 000,00	15 613 320,00
210402	Тээвэр, шатахуун	46 500 000,00	46 478 910,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9 400 000,00	8 386 861,61
210404	Ном, хэвлэл	1 680 000,00	760 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12 030 000,00	6 650 635,00
2105	Нормативт зардал	607 700,00	607 670,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	607 700,00	607 670,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115 050 000,00	109 528 380,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36 050 000,00	31 878 600,00
210604	Урсгал засвар	79 000 000,00	77 649 780,00
2107	Томилолт, зочны зардал	15 181 600,00	11 006 000,00
210702	Дотоод албан томилолт	15 181 600,00	11 006 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23 950 000,00	21 023 933,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19 500 000,00	17 348 280,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 000 000,00	1 000 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1 070 000,00	391 757,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150 000,00	55 000,00
210807	Газрын төлбөр	2 230 000,00	2 228 896,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	573 157 100,00	559 382 559,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	551 157 100,00	537 452 552,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22 000 000,00	21 930 007,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109 944 200,00	109 764 897,58
2132	Бусад урсгал шилжүүлэг	109 944 200,00	109 764 897,58
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	17 000 000,00	16 938 600,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15 641 000,00	15 641 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77 303 200,00	77 185 297,58
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 829 087 100,00	1 771 013 900,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 829 087 100,00	1 771 013 900,00
132001	Орон нутгийн төсвөөс	1 829 087 100,00	1 771 013 900,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00	01
620001	Удирдах ажилтан	00	01
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	82	62
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	22	21
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	25	07
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	21
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	13	13

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	193 082 360,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	193 082 360,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	189 611 430,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	189 611 430,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	189 611 430,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2 127 700,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2 127 700,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2 127 700,00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1 343 230,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	193 082 360,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	193 082 360,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	193 082 360,00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн онцлогт нийцсэн олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлж, цахимд суурилсан төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. Байгууллагын чиг үүрэг нь төрийн захиргааны байгууллага бөгөөд иргэдэд төрийн анхан шатны үйлчилгээг үзүүлэн, сумын хэмжээнд бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдэд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үйл ажиллагаа юм.

Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 637,219.7 мянган төгрөгөөр буюу 14.9%-аар өссөн байна. Үүнд:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 он	2022 он	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авлага	17 670 908,00	6 740 310,00	-10 930 598,00	-
Бараа материал	277 891 015,41	324 133 244,21	46 242 228,80	14,3%
Үндсэн хөрөнгө	3 357 202 796,51	3 959 110 912,69	601 908 116,18	15,2%
Нийт хөрөнгө	3 652 764 719,92	4 289 984 466,90	637 219 746,98	14,9%
Өр төлбөр	42 149 273,00	2 752 340,00	-39 396 933,00	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3 610 615 446,92	4 287 232 126,90	676 616 679,98	15,8%
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3 652 764 719,92	4 289 984 466,90	637 219 746,98	14,9%

Авлага тайлант хугацаанд 10,930.6 мянган төгрөгөөр буурсан бөгөөд Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,959,110.9 мянган төгрөг болж, 601,908.1 мянган төгрөгөөр буюу 15.2%-иар, бараа материалын үлдэгдэл 324,133.2 мянган төгрөг болж 46,242.2 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна.

2022 оны захирамж, шийдвэр гарсан Э-121300094 гэрчилгээний дугаартай 639,075.0 мянган төгрөгийн газар, Э-1213000349 гэрчилгээний дугаартай 30,060.0 мянган төгрөгийн газар Нийт 669,135.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг биет бус хөрөнгөд бүртгэн авсан байна.

Сүхбаатар аймгийн баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны 15/12 тоот тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын 103,075.7 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөөр, 47,500.0 мянган төгрөгийн ариутгалын автомашиныг тээврийн хэрэгсэлээр, Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, Тамгын даргын Б/137 тоот тушаалын дагуу төсвийн хөрөнгөөр худалдан авсан 22,478.3 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмжөөр, 10,896.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөөр, 1,995.0 мянган төгрөгийн программ хангамжийг тус тус бүртгэлд нэмж тусгасан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 1-ны Д/432 тоот албан бичгээр 36,883.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 24,312.4 мянган төгрөгийн Тавилга эд хогшил, 13,721.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 915.0 төгрөгийн программ хангамж, нийт 75,831.7 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий хөрөнгийг актлах зөвшөөрөл ирсэний үндсэн дээр хөрөнгийг баланс бүртгэлээс хасалт хийсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,287.2 сая төгрөг болж, 637.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,635,334.4 мянган төгрөг буюу 58.0 хувиар буурсан нь Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,133,262.0 төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого /ковид-19 холбоотой нэмэлт санхүүжилтүүд/ 920,179.7 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Үүнд:

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 он	2022 он	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4=3/2
Үйл ажиллагааны орлогын дун	4 454 141 374,00	2 818 806 990,00	-1 635 334 384,00	-58%
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1 987 972 693,00	854 710 730,00	-1 133 261 963,00	-133%
Тусламж, санхүүжилтийн орлого	10 797 240,00	193 082 360,00	182 285 120,00	94%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1 352 906 600,00	1 771 013 900,00	418 107 300,00	24%
Үйл ажиллагааны зардлын дүн	2 637 912 578,16	2 141 139 391,46	-496 773 186,70	-23%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	135 957 206,00	132 717 451,21	-3 239 754,79	-2%
Гэрэл, цахилгаан	9 367 053,00	7 427 324,77	-1 939 728,23	-26%
Түлш, халаалт	55 590 153,00	53 069 744,24	-2 520 408,76	-5%
Цэвэр, бохир ус	2 200 000,00	2 620 382,20	420 382,20	16%
Байрны түрээс	68 800 000,00	69 600 000,00	800 000,00	1%
Хангамж, урсгал засварын зардал				
Бичиг хэрэг	18 002 990,00	22 710 400,00	4 707 410,00	21%
Тээвэр, шатахуун	34 339 000,00	43 392 050,00	9 053 050,00	21%
Шуудан, холбоо, интернэт	7 315 132,00	8 355 841,61	1 040 709,61	12%
Багаж, техник, хэрэгсэл	64 500,00	5 180 300,00	5 115 800,00	99%
Урсгал засвар	36 265 180,21	74 218 491,20	37 953 310,99	51%
Дотоод албан томилолт	8 903 000,00	11 006 000,00	2 103 000,00	19%
Бараа үйлчилгээний бусад зардал	333 318 005,59	548 364 752,00	215 046 746,41	39%

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 496,773.2 мянган төгрөгөөр буюу 23 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс Байрны ашиглалтын зардал буюу цахилгаан, халаалт, цэвэр бохир усны зардал 3,239.7 мянган төгрөг буюу 2 хувиар буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 1,964,096.3 мянган төгрөгөөр, санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс: Орон нутгийн төсвөөс 1,771,013.9 мянган төгрөг, үйл ажиллагааны нэмэлт орлогоос 193,082.4 мянган төгрөг, нийт зарлагыг 2,141,139.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна. Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 33 зорилтын хүрээнд 117 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 92.4 хувьтай биелүүлсэн. Дээрх арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,829,087.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,771,013.9 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 96.8 хувьтай хэрэгжсэн байна

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хувь
1	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	17 000 000,00	16 938 600,00	61 400,00	36,0%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	45 180 900,00	45 107 290,58	73 609,42	16,0%
3	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	100 000 000,00	98 784 555,00	1 215 445,00	121,0%
4	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	447 407 100,00	437 919 358,00	9 487 742,00	940,0%
5	81549-Ахмадын сан	3 750 000,00	748 639,00	3 001 361,00	8000,0%
	Нийт дүн	613 338 000,00	599 498 442,58	13 839 557,42	92,39%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 193,082.4 мянган төгрөгийн орлогыг санхүүжүүлсэн байна. Үүнээс: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 189,611.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 2,127.7 мянган төгрөгийг зарцуулж, 1,343.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 33 зорилтын хүрээнд 117 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 92.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг хавсаргав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах М.Уламбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 26,379.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,465.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд нийт зардал 496,773.2 мянган төгрөг буюу 23.2%-иар буурсан байна. 0909-СҮА улсын дугаартай Ланд круйзер маркийн автомашины урсгал засварт 24,005.3 мянган төгрөгийн засвар хийгдсэн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд нийт 1,496,858.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1.-д “...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр), Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр), Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) зэрэг 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 40.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 24.1 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	15,862.7	1	15,862.7	100%
Зөвлөмж	4	24,137.3	4	24,137.3	100%
Нийт дүн	4	40,000.0	4	40,000.0	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар аливаа акт, албан шаардлага хүргүүлэх асуудлууд илрээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Байгууллага нь нийт 18 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 19,866.1 мянган төгрөгийн худалдан авалтын баримт татварын цахим системд дутуу шивэгдсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэснийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн:

Худалдан авалтын мэдээллийг татварын нэгдсэн системд мэдээлсэн эсэхийг шалгах, мэдээлээгүй тохиолдолд харилцагч байгууллагад хандан системд шивүүлэх;

5.2 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой. Шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан дараах мэдээллүүд байна. Үүнд:

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр),
2. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр),
3. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан цаг хугацаанд тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	3	-	-	-	-	-	-	-	-	-	3	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
татварын цахим системд дутуу шивэгдсэн	1	-	-	-	1	-	-	-
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	3						3	-
Дүн	4	-	-	-	1	-	3	-